

**“Хай Би Ойл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2026.04.27-ны өдрийн ээлжит хурлын
тэмдэглэл**

2026.04.27

Улаанбаатар хот

“Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 27-ний өдрийн Даваа гаригт Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, 18135, товчооны зам гудамж, 59 тоот өөрийн байранд 10:00 цагт эхлэв.

Хуралд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх захирал Ш.Амар-Отгон, Нягтлан бодогч О.Ганчимэг хурал зохион байгуулах комиссын гишүүн Н.Батнайрамдал, Л.Даваагэрэл нар мөн нийт 5 хувьцаа эзэмшигчид оролцов.

Хурал зохион байгуулах комиссын гишүүн Н.Батнайрамдал “Хай Би Ойл” ХК-ийн 2026 оны 04 сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг та бүхэнд танилцуулъя. Нийт 52,118,954 хувьцаанаас нийтдээ 91,47% буюу 46,377,976 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэйгээр хурлын ирц бүрдсэн тул хурлаа эхэлж байна. Хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой танилцуулгыг Гүйцэтгэх захирал та бүхэнд танилцуулна.

Хурлын дарга Ш.Амар-отгон: Сайн байцгаана уу. Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. “Хай Би Ойл” ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээснийг мэдэгдье. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа

Өнөөдрийн хурлыг “Хай Би Ойл” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ш.Амар-отгон миний бие даргалах бөгөөд хурлаар хэлэлцэх асуудал болон хурлын дэг, компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг өгнө.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
3. Энэ жилийн ногдол ашгийн талаарх гаргасан ТУЗ-ын шийдвэрийг танилцуулна.

Миний бие “Хай Би Ойл” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар 7 дахь жилдээ ажиллаж байгаа Ш.Амар-Отгон гэж хүн байна. Та бүхэнд хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материал тараасан байгаа та бүхэн танилцаарай. Бид 2025 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг та бүхэнд танилцуулна. Би үйл ажиллагааныхаа тайланг ерөнхийд нь танилцуулна. Манай нягтлан бодогч О.Ганчимэг санхүүгийн тайлан, аудитын тайланг танилцуулах болно.

“Хай Би Ойл” ХК-ний үй ажиллагааны тайланг танилцуулъя. Бид өнгөрсөн 2025 онд ачаалал ихтэй, үр өгөөжтэй, маш сайн ажилласан гэж харж байгаа. Хай Би Ойл ХК нь нийт 10 ажилтантай ажиллаж байгаа, үүнд Гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, менежер, харуул, үйлдвэрийн дарга, ахлах оператор, туслах 2 оператор, ТУЗ нарийн бичгийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Бид 2025 оны 04-р сарын 01-ны өдрөөс ажиллаж эхэлсэн. Үйлдвэрлэл борлуулалтын тухайд бол манай компани 2025 онд ажилласан 7 сарынхаа хугацаанд нийт 33-н аж ахуй нэгжтэй техникийн хаягдал тос цуглуулах гэрээ байгуулсны

дагуу нийт Өмнөх оны түүхий эд болох хаягдал тосны үлдэгдэл 254,106 литр, Мазут буюу боловсруулсан тосны үлдэгдэл 3,703 литр байсан ба 2025 оны хагас жилийн тайлант хугацаанд цуглуулсан хаягдал тос 726,462 литр байна. Нийт 657,170 тонн мазут боловсруулан борлуулсан байна.

2025 оны 4 сар эхлээд Байгаль орчны яам болон Уул уурхайн яам, Стандарт хэмжилзүйн газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар зэрэг газруудаас ээлж дараатай шалгалтууд хийгдсэн бөгөөд шалгалтаар хугацаатай болон хийх ажлуудын даалгаврууд өгснийг цаг тухай бүрд нь биелүүлэн ажилласан. Мөн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас олгодог “Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх” тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан тул 2025 оны 4 дүгээр сард холбогдох материалыг бүрдүүлэн хүргүүлсэн. Үүний үр дүнд тусгай зөвшөөрлийг 2025 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 10 жилийн хугацаагаар сунгуулсан

Хот дотор явж тосоо цуглуулдаг тээврийн хэрэгслүүддээ авто тээврийн газраас холбогдох зөвшөөрлүүдийг авсан. Ажилчдаа Сонгдо эмнэлэг дээр жил бүр эмчийн үзлэгт хамруулдаг бөгөөд энэ жил мөн эрүүл мэндийн үзлэгтээ хамрагдсан. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээнд нэгдэн оролцсон. Энэ хүрээнд “Нүри” ХХК-тай мод тарих ажлын гэрээ байгуулж, “Инчон мөрөөдлийн төгөл”-д 200 ширхэг хайлаас мод тарьсан.

Байгаль орчны төлөв байдлын судалгааны ажлын хүрээнд төслийн талбайгаас худгийн ус, бохир ус, агаар, хөрсний бохирдлын түшинг тодорхойлох зорилгоор дээж авч “Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори” ХХК-ийн хөрс судлалын лабораторид өгч шинжлүүлсэн.

“Хай Би Ойл” ХК нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаа гаргаад “Пантер мидлант аудит” ХХК-аар аудит хийлгэсэн. 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн талаар нягтлан бодогч О.Ганчимэг танилцуулна.

“Хай Би Ойл” ХК-ийн нягтлан О.Ганчимэг: “Хай Би Ойл” ХК-ийн нягтлан бодогч О.Ганчимэг байна. Хуралд оролцож байгаа та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. 2025 оны тайлангийн үзүүлэлтүүдийг танилцуулъя.

2025 оны 4-р улиралд нийт хөрөнгийн дүн 5,739.5 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 19,6% буюу 1,122,6 сая төгрөг, эргэлийн бус хөрөнгө 80,4% буюу 4,616,8 сая төгрөг байна.

Нийт хөрөнгийн эх үүсвэр 5,739.5 сая төгрөг, үүнээс өр төлбөр нь 134.4 сая төгрөг, эзний өмч 5,605,0 сая төгрөг байна

Орлогын тайлан

2025 оны нийт орлого 1,512.4 сая төгрөгийн орлоготой 302,6 сая төгрөгийн зардал, 5.8 сая төгрөгийн бусад зардал, 589,9 сая төгрөгийн ашигтай ажилласан.

Өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 онд ашигтай ажиллаж 4-р улирлын эцэст эзний өмчийн дүн 5,605.0 сая төгрөг байна

Мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 4-р улиралд мөнгөн орлого 1,704.2 сая төгрөг, зарлага нь 875.8 сая төгрөг, үйл ажиллагаа гүйлгээ 828,4 сая төгрөг, улирлын эцсийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл 606,0 сая төгрөг

“Хай Би Ойл” ХК нь 2025 онд хэдийгээр компани ашигтай ажилласан ч ногдол ашиг тараах боломжгүй байсан. Тухайн ашгаараа бид 2026 оныхоо ажлын эргэлтийн хөрөнгөнд ашиглах ёстой үүнд ажилчдын цалин түүхий эд цуглуулах тээврийн зардал гэх мэт байна.

2025 онд түүхий эдийн хомсдол үүсэж дандаа худалдаж авч цуглуулсан. Мөн тог цахилгааны үнэ нэмэгдсэн, манай үйлдвэр 100 хувь тоогоор ажилдаг.

Гүйцэтгэх захирал Ногдол ашгийн тухайд: ТУЗ-ын ногдол ашиг тараахгүй гэсэн шийдвэрийг танилцуулъя аа. Компанийн 2025 оны 12 сарын 31-ны үлдэгдлээр ашигтай ажилсан ч энэ нь компанийн 2026 оны ажлын эхний эргэлтийн хөрөнгөд зарцуулагдахаар байгаа, хэдийгээр ашигтай ажилласан гэж харагдаж байгаа ч дансанд байгаа бэлэн мөнгө нь бага, авах авлагууд байгаа бөгөөд зарим нь шүүхийн шатанд явж байна. Түүхий эдийн үнэ энэ жил маш их өссөн буюу 750-1000 төгрөг болсон тул бид байгаа хэдэн төгрөгөөрөө түүхий эд авах, ажилчдынхаа цалинг тавих, бусад зардалд зарцуулах шаардлагатай байгаа тул ногдол ашиг тараах боломжгүй гэж үзээд ногдол ашиг тараахгүй гэсэн шийдвэр гарсан байгаа шүү.

Компанийн үйл ажиллагаа улирлын чанартай буюу яг идэвхтэй ажилдаг 7 сар л байдаг үлдсэн 5 сард нь сул зогсдог, 7 сардаа хийсэн ажлын борлуулалт нь тухайн жилийнхээ зардал болон ирэх жилийн ажиллах эргэлтийн хөрөнгөндөө зарцуулагдаад түүнээсээ илүү гарахгүй л байна. Бид боловсруулсан бүтээгдэхүүнээ л зардаг, энэ жил тог цахилгаан, түүхий эдийн үнэ нэмэгдсэнтэй холбогдуулаад бүтээгдэхүүнийхээ үнийг тодорхой хэмжээгээр нэмсэн.

Уг нь хаягдал тосыг тусгай зөвшөөрөлтэй газруудад нийлүүл гэж авто засварын газруудад холбогдох төрийн байгууллагуудаас шаардлага тавьдагч дийлэнх газрууд манайхтай гэрээ байгуулчхаад гэрээнийхээ дагуу нийлүүлэхгүй, тусгай зөвшөөрөлгүй, жижиглэнгээр авдаг хүмүүст арай өндөр үнээр зараад байгаа асуудлууд гарч байгаа. Хаягдал тосыг боловсруулахгүйгээр гар аргаар шатаагаад байгаа хүмүүс бас байна.

Хурлын төгсгөлд хурлын дарга Ш.Амар-отгон тооллогын гишүүдээс ирсэн санал хураалтын дүнг танилцуулав:

Тооллогод нийт хувьцаа эзэмшигчдийн 91.47% буюу 47,672,450 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас ирснээс 91.47 буюу 100% хүчинтэй байлаа.

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.
2. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгоход кумулятив аргаар өгсөн саналын дүн:

Кумулятив аргаар ердийн гишүүдэд өгсөн хувьцааны нийт тоо: 286,034,700

	Нэр	Саналын хувь
1	Ш.Амар-Отгон	12.7
2	Б.Батбаатар	10.8
3	Б.Дөлгөөнтамир	10.8

4	У.Энхбилэг	10.8
5	С.Одгэрэл	10.8
6	Р.Оюунбат	10.8

саналын хувьтайгаар “Хай Би Ойл” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүдэд сонгогдлоо.

Кумулятив аргаар хараат бус гишүүдэд өгсөн хувьцааны нийт тоо: 143,017,350

	Нэр	Саналын хувь
1	Б.Гэрэлтуяа	10.8
2	Т.Тамир	11.7
3	Г.Бадамдорж	10.8

саналын хувьтайгаар “Хай Би Ойл” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүдэд тус тус сонгогдлоо.

“Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны хуралд маань цаг заваа гарган оролцсон та бүхэндээ баярлалаа.

Хурал 11:00 дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ХУРЛЫН ДАРГА:



Н.БАТНАЙРАМДАЛ

Ш.АМАР-ОТГОН